



НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

128/ШЗ2024/5342
Дугаар _____

Улаанбаатар хот

Хүсэлт хэлэлцэж, шүүх хуралдаан
товлон зарлах тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч Л.Батбаатар даргалж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга О.Тэмүүлэн, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Түмэнбаяр нарыг оролцуулан "Урагшлах" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тус тус холбогдох захиргааны хэргийг тус шүүхийн шүүх хуралдааны 3 дугаар танхимд урьдчилсан хэлэлцүүлгийн журмаар хянан хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан хүсэлтдээ: "...Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас хариу тайлбар болон итгэмжлэгдсэн төлөөлөгч ирээгүй..., урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах тоот ирүүлсэн ..., уг хүсэлтдээ нотлох баримтыг хавсаргаагүй байна. Хүсэлтийн агуулгад тодорхойлсон урьдчилсан санал асуулга гэх зүйлийг ойлгохгүй байна. Нэгийгээ төлөөлөөд нөгөө төлөөлөгч нь ирэх боломжтой байсан гэж үзэж байна.

...Нэхэмжлэгчээс 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн байгаа...,

...Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийн тухайд Актын биелэлт түдгэлзүүлэх хүсэлтээ бичгээр гаргасан байгаа..., Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан нөхцөл байдалд хамаарахгүй тул мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-д "...хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ...", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д "Шүүх захиалагчийн шийдвэр, худалдан авах гэрээний биелэлтийг түдгэлзүүлэх нь нийтийн ашиг сонирхолд илтэд хохиролтой гэж үзсэнээс бусад тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар түдгэлзүүлж болно" гэж заасныг үндэслэсэн. Иймд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж өгнө үү..." гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

1. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Түмэнбаярын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гаргасан "...Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн НХААГ/202401011027 дугаартай "Хороо, ерхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дахин

140213317

зарласан шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү..." хэмээн нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн байна.

Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх,...; заасан бүрэн эрхийг эдэлнэ... энэ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д "Шүүгч энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан, эсхүл нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлсэн өдрөөс хойш долоо хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана" гэжээ.

Хавтас хэрэгт авагдсан итгэмжлэл¹ болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.2-54.1.8 дахь заалтад заасан нэхэмжлэлийн ихэсгэсэн шаардлагыг хүлээн авахаас татгалзах үндэслэл тогтоогдохгүй байх тул захиргааны хэрэг үүсгэх үндэслэлтэй гэж үзлээ.

2. Нэхэмжлэгч "Урагшлах" ХХК-иас Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн НХААГ/202401011027 дугаартай "Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зарласан шийдвэрийг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргажээ²

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ хэмээн хуульчилсан ба мөн хуулийн 62 дугаар зүйлд актыг түдгэлзүүлж болохгүй нөхцөлүүдийг тусгайлан зохицуулжээ.

Энэ тохиолдолд маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлснээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар нөхцөл байдал үүсэхээргүй буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасанчлан түдгэлзүүлж болохгүй нөхцөлүүд тогтоогдохгүй байна.

Иймд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь нэхэмжлэгчид эрх зүйн түр хамгаалалт бий болгох зорилгоор Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн НХААГ/202401011027 дугаартай "Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зарласан шийдвэрийг энэ хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэхээр шийдвэрлэв.

3. Харин Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4.2-т заасан хугацаа дуусаж байх тул мөн хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг товлон зарлахаар тогтов.

4. Эцэст нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан урьдчилсан хэлэлцүүлэгт хариуцагч Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны албанаас 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 472 дугаар албан бичгээр "...сонгуулийн урьдчилсан санал хуралттай байгаа ..." үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт ирүүлсэн ч энэ тухай баримтыг ирүүлээгүй.

Мөн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаантай болох талаар хүсэлтээ холбогдох баримтын хамт ирүүлээгүй байх тул шүүх өмнө Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.8 дахь хэсэгт заасны дагуу

¹ Хавтас хэргийн 7-8 хуудас

² Хавтас хэргийн 113 хуудас

нэг удаа хойшлуулсан зэргийг харгалзан үзээд энэ удаагийн шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн хариуцагчийн төлөөлөгчийн оролцуулахгүйгээр хийсэн болохын дурдах нь зүйтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д заасныг тус тус удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасныг баримтлан "Урагшлах" ХХК-иас Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газарт холбогдуулан гаргасан Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн НХААГ/202401011027 дугаартай "Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зарласан шийдвэрийг хүчингүй болгуулах" шаардлага бүхий нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэсүгэй.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 62 дугаар зүйлийн 62.1.1-д дэх хэсэгт заасныг баримтлан Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн НХААГ/202401011027 дугаартай "Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга /Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зарласан шийдвэрийн биелэлтийг уг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлсүгэй.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасныг баримтлан "Урагшлах" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд холбогдох захиргааны хэргийн шүүх хуралдааныг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 14.00 цагт хийхээр товлон зарласугай.

Захирамжийг хэргийн оролцогчдод танилцуулах, шүүх хуралдааныг товыг товлон мэдэгдэхийг шүүгчийн туслах Ч.Золжаргалд даалгасугай.
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.4-т заасны дагуу шүүгчийн энэхүү гомдол гаргах эрхгүй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ



Л.БАТБААТАР